



# UniStar-Audit LLC

ACCOUNTING, AUDITING, ASSURANCE, CONSULTING,  
VALUATION AND TAX SERVICE

СБД, 8-р хороо, Амарын гудамж,  
Мигма төв 306 тоот  
Утас: 3287358 99168961, 99994372  
E-mail: info@unistaraudit.mn

2019.03.29 ' 19/09  
Танай \_\_\_\_\_ № \_\_\_\_\_

ХАЙ БИ ОЙЛ ХК-ИЙН  
ХУВЬЦАА  
ЭЗЭМШИГЧДЭД

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

### Дүгнэлт

Бид Хай Би Ойл ХК-ийн 2018 оны 12 сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөрх жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь **Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл** хэсэгт дурдсан зүйлээс бусад бүх материаллаг зүйлсийн хувьд Хай Би Ойл ХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрхи санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болгон бэлтгэсэн тайлант жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт болон Монгол Улсад мөрдөж байгаа холбогдох заавар, журмын дагуу үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Компанийн удирдлага **Санхүүгийн тайлангийн тодруулга 5 - Өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт**-д дурдсан Сингапур улсын хуулийн этгээд "Блектип Энержи Лимитед" компанийн нэг бүр нь 0.36 сингапур долларын үнэтэй 3,633,450 ширхэг энгийн хувьцаа (нийт энгийн хувьцааны 13%)-нд оруулсан хөрөнгө оруулалтад 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр аливаа үнэ цэнийн бууралтыг бүртгээгүй байна. Бид энэ гадаад улс дахь хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн тооцооллыг баталгаажуулахтай холбоотой мэргэжлийн зөвлөхийн ажлыг ашиглах эсвэл өөр аудитын горим гүйцэтгэх боломжгүй байсан тул аливаа үнийн бууралт байхгүй гэсэн ул үндэслэлтэй нотолгоо цуглуулах замаар аудитын эерэг санал дүгнэлт гаргах боломжгүй байсан.

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт(АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн. Уг стандартын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэхүү тайлангийн санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулав. Бид Монгол улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бус байсан бөгөөд хуулиар шаардсан шаардлагын дагуу ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан санал дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай бөгөөд зохистой гэж найдаж байна.

## **ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)**

### **Асуудлыг онцлох нь**

Санхүүгийн тайлангийн Санхүүгийн тайлангийн тодруулга 16 - Болзошгүй алдагдалд дурдсан Шарын гол ХК-иас авах нийт 2,300,093.9 мянган төгрөгийн авлага эргэн төлөгдөх эсэх нь харилцан хамаарал бүхий Хай Би Ойл ХК болон Шарын гол ХК-ийн томоохон хувьцаа эзэмшигчдийн шийдвэр гаргалтаас хамаарахаар байгааг энэхүү санхүүгийн тайлан хэрэглэгчдийн анхааралд хүргэж байна. Бид энэхүү авлагатай холбоотойгоор дээр гаргасан дүгнэлтийн хэлбэрийг өөрчлөөгүй болно.

### **Бусад мэдээлэл**

Компанийн удирдлага бусад мэдээлэлд үүрэг хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь жилийн тайланд ордог мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон аудиорын тайлан ордоггүй. Санхүүгийн тайлангийн талаар гаргасан бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамардаггүй бөгөөд бид бусад мэдээллийн талаар аливаа баталгаажуулалт, дүгнэлт гаргахгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбогдуулан бид бусад мэдээллийг уншиж, санхүүгийн тайлан, аудитаар олж авсан бидний мэдлэг, мөн өөр хэлбэрээр материаллагаар буруу илэрхийлэгдсэн байж болох эсэх тухай асуудлыг авч үздэг. Бид өөрсдийн хийж гүйцэтгэсэн ажилдаа суурилан энэхүү бусад мэдээлэл нь материаллаг буруу илэрхийлэлтэй байна гэж дүгнэвэл энэ тухай тайландаа тусгах ёстой. Бидэнд ингэж тайлагнах зүйл байхгүй болно.

### **Санхүүгийн тайланд Удирдлага ба Засаглах удирдлагын хүлээх үүрэг хариуцлага**

Эдгээр санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэж үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага юм. Зальт ажиллагаа буюу алдаанаас үүдсэн материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайланг бэлтгэж, үнэн зөв толилуулахтай холбогдсон дотоод хяналтыг төлөвлөх, хэрэгжүүлэх нь энэхүү хариуцлагад хамаарна. Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага нь компанийг татан буулгах, үйл ажиллагаагаа зогсоох эсвэл ингэхээс өөр сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх хариуцлагыг хүлээх ба шаардлагатай бол тасралтгүй байдалтай холбоотой асуудлуудын талаар тодруулга хийх, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байдлын суурийг хэрэглэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Мөн засаглах удирдлага нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

### **Аудиторын хүлээх хариуцлага**

Бидний зорилго бол санхүүгийн тайлангууд нь заль мэх эсвэл алдаанаас үүдсэн материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах, өөрийн санал дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан гаргах явдал юм. Үл үндэслэлтэй баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудитаар оршин байгаа материаллаг алдаа зөрчил бүрийг ямагт илрүүлнэ гэсэн баталгаа гаргадаггүй. Заль мэх эсвэл алдаанаас шалтгаалан буруу тайлагнал үүсч болох ба тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай юм.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх байр сууринаас хандаж мэргэжлийн шийдэл гарган ажилласан. Мөн бид:

- Заль мэх эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг алдаатай илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж, үнэлэн уг эрсдэлд тохирох аудитын горимыг

## Хай Би Ойл ХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн санал дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой нотолгоог олж авдаг. Заль мэхнээс үүссэн үгсэн хуйвалдах, баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу тайлагнах, дотоод хяналтыг үл ойшоох зэргээс шалтгаалсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлтэй.

- Компанийн дотоод хяналтын үр ашигт байдлын талаар санал дүгнэлт гаргах зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг боловсруулах зорилгоор аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, хийсэн тооцоолол болон холбогдох тодруулгын ул үндэстэй байдлыг үнэлдэг.
- Мөн компанийн тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх чадамжинд мэдэгдэхүйц эргэлзээ төрүүлэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг тодорхойлж, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байдлын суурийг удирдлага зохистойгоор хэрэглэсэн эсэхийг дүгнэдэг. Хэрэв компанийн тасралтгүй байх чадавхид тодорхойгүй байдал байна гэж үзвэл бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл хийсэн тодруулга хангалтгүй байна гэж үзвэл аудитын санал дүгнэлтээ өөрчилдөг. Бидний дүгнэлт нь аудиторын тайлан гаргах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд суурилдаг. Гэхдээ компанийн тасралтгүй байх чадавхид нөлөөлөх нөхцөл байдал, үйл явдал ирээдүйд үүсч болох юм.
- Санхүүгийн тайлангийн толилуулга, бүтэц, агуулга, тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангууд нь үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол гол ажил гүйлгээ ба үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.
- Бид аудитын цар хүрээ, хугацаа, аудитын явцад олж илрүүлсэн томоохон чухал асуудлууд болон ажиглагдсан дотоод хяналтын сул талуудын талаар эрх бүхий удирдлагатай харилцдаг.

### Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 95.1 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох Хай Би Ойл ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.




Огноо: 2019.03.29

## 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

## 4.1. Санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Тэм	2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2018 оны 12 сарын 31- ний үлдэгдэл
<b>ХӨРӨНГӨ</b>			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө		13,640,999.08	51,945,419.62
Дансны авлага		1,313,971,201.00	1,500,438,003.91
Татвар, НДШ-ийн авлага		-	13,982,552.65
Бусад авлага		451,194,893.68	483,890,994.60
Бараа материал		123,893,540.20	123,568,284.77
Урьдчилж төлсөн зардал/тооцоо		38,392,003.91	39,205,502.86
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>		<b>1,941,092,637.87</b>	<b>2,213,030,758.41</b>
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө		1,257,356,848.40	1,187,285,930.40
Урт хугацаат хөрөнгө оруулалт		1,636,952,132.00	1,636,952,132.00
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>		<b>2,894,308,980.40</b>	<b>2,824,238,062.40</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>4,835,401,618.27</b>	<b>5,037,268,820.81</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ӨМЧ</b>			
<b>ӨР ТӨЛБӨР</b>			
Богино хугацаат өр төлбөр			
Дансны өглөг		248,110,776.54	302,633,872.28
Цалингийн өглөг		128,362,989.49	129,136,875.43
Татварын өр		106,046,015.04	2,558,484.28
НДШ-ийн өглөг		3,243,799.65	-
Бусад богино хугацаат өр төлбөр		110,138,112.00	117,809,055.00
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>		<b>595,901,692.72</b>	<b>552,138,286.99</b>
Урт хугацаат өр төлбөр			
Хойшлогдсон татварын өр			71,449,317.58
<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>		<b>-</b>	<b>71,449,317.58</b>
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>		<b>595,901,692.72</b>	<b>623,587,604.57</b>
Эздийн өмч			
Өмч : хувьцаат		5,211,895,400.00	5,211,895,400.00
Нэмж төлөгдсөн капитал		4,592,503,138.14	4,592,503,138.14
Хуримтлагдсан ашиг (алдагдал)		(5,564,898,612.59)	(5,390,717,321.90)
<b>Өмчийн дүн</b>		<b>4,239,499,925.55</b>	<b>4,413,681,216.24</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН</b>		<b>4,835,401,618.27</b>	<b>5,037,268,820.81</b>



## 4.2. Орлогын дэлгэрэнгүй тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Тэм	2017 оны дүн	2018 оны дүн
Борлуулалтын орлого		561,474,727.26	950,149,642.90
Борлуулсан бүтээгдхүүний өртөг		(420,075,855.14)	(629,251,222.82)
Нийт ашиг (алдагдал)		141,398,872.12	320,898,420.08
Хүүгийн орлого		98,495,651.43	1,719,461.78
Бусад орлого		40.05	180,000.50
Ерөнхий ба удирдлагын зардал		(298,840,327.06)	(282,087,814.78)
Бусад зардал		(3,607,862,098.32)	(4,207,520.96)
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		(23,276,029.75)	156,114,971.65
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		(3,690,083,891.53)	192,617,518.27
Орлогын татварын зардал-Орлогын татвар		(9,849,565.36)	(3,924,070.42)
Хойшлогдсон орлогын албан татварын зардал		-	(15,611,497.16)
Татварын дараах ашиг алдагдал		(3,699,933,456.89)	173,081,950.69
Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал		(3,699,933,456.89)	173,081,950.69
<b>Нийт дэлгэрэнгүй орлогын дүн</b>		<b>(3,699,933,456.89)</b>	<b>173,081,950.69</b>
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		(70.99)	3.32



4.3. Өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2016 оны 12 сарын 31 - нээрх үлдэгдэл	5,211,895,400.00	4,592,503,138.14	(1,864,965,155.70)	7,939,433,382.44
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				
Залруулсан үлдэгдэл	5,211,895,400.00	4,592,503,138.14	(1,864,965,155.70)	7,939,433,382.44
Тайлант үеийн цэвэр ашиг			(3,699,933,456.89)	(3,699,933,456.89)
2017 оны 12 сарын 31 - нээрх үлдэгдэл	5,211,895,400.00	4,592,503,138.14	(5,564,898,612.59)	4,239,499,925.55
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			-	-
Залруулсан үлдэгдэл	5,211,895,400.00	4,592,503,138.14	(5,564,898,612.59)	4,239,499,925.55
Тайлант үеийн цэвэр ашиг			173,081,950.69	173,081,950.69
Бусад дэлгэрэнгүй орлого			1,099,340.00	1,099,340.00
2018 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл	5,211,895,400.00	4,592,503,138.14	(5,390,717,321.90)	4,413,681,216.24



## 4.4. Мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Тэм	2017 оны дүн	2018 оны дүн
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>		<b>711,088,179.00</b>	<b>1,065,091,750.00</b>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого		711,088,150.00	1,065,091,750.00
Бусад орлого		29.00	
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага</b>		<b>(832,441,606.60)</b>	<b>(1,023,803,869.22)</b>
Ажиллагчдад төлсөн		(171,856,065.23)	(164,968,285.20)
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн		(42,243,943.80)	(50,907,245.05)
Бараа материал худалдан авахад төлсөн		(214,196,000.00)	(380,015,950.00)
Ашиглалтын зардлад төлсөн		(3,195,033.00)	(4,658,600.00)
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		(88,181.83)	(970,000.00)
Татварын байгууллагад төлсөн		(79,322,467.63)	-183,065,825.16
Бусад мөнгөн зарлага		(321,539,915.11)	-239,217,963.81
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		<b>(121,353,427.60)</b>	<b>41,287,880.78</b>
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>		<b>1,487,177.22</b>	<b>1,420,342.85</b>
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		2,116.69	
Хүлээн авсан хүүний орлого		1,485,060.53	1,420,342.85
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>		<b>-</b>	<b>(4,430,000.00)</b>
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		-	(4,430,000.00)
Хөрөнгө оруулалтын ү/а-ны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		1,487,177.22	(3,009,657.15)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>		<b>-</b>	<b>-</b>
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>		<b>(304,881.44)</b>	<b>26,196.91</b>
Валютын ханшийн ашиг/алдагдал		(304,881.44)	26,196.91
<b>Санхүүгийн ү/а-ны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		<b>(304,881.44)</b>	<b>26,196.91</b>
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>(120,171,131.82)</b>	<b>38,304,420.54</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		133,812,130.90	13,640,999.08
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		13,640,999.08	51,945,419.62

